



Монгол Улсын Их
Хурлын Тамгын газар



ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГААНЫ
ХҮРЭЭЛЭН

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТУУД

(Харьцуулсан судалгаа)
СТ-20/202

Захиалагч: Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд
Хянасан: Д.Бадамдаш
Гүйцэтгэсэн: Г.Алтан-Оч
Р.Нургүл

Улаанбаатар
2020 он

АГУУЛГА

СУДЛАГДСАН БАЙДАЛ

СУДАЛГААНЫ ОРШИЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ
ЗОХИЦУУЛАЛТУУД**

1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
2. Бүгд Найрамдах Казахстан Улс
3. Бүгд Найрамдах Эстони Улс

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

СУДЛАГДСАН БАЙДАЛ

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуультай шууд холбогдох дэлгэрэнгүй харьцуулсан судалгааг¹ УИХТГ-ын Судалгааны төвийн судлаач Д-р Ч.Базар 2011 онд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн бөгөөд уг судалгаа нь доорх бүлгүүдийг агуулсан болно. Үүнд:

1. Үндэсний аюулгүй байдал ба Мэдээллийн эрх чөлөө
2. Үндэсний аюулгүй байдал ба Төрийн нууц
3. Яагаад Үндэсний аюулгүй байдал чухал вэ?
4. Мэдээллийн аюулгүй байдал ба гадаад улс орнуудын зохицуулалт
5. Хувийн мэдээллийн нууцлалт
6. Мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой байгууллагуудын зохицуулалт
7. Мэдээллийн аюулгүй байдал-Мэдээлэл авах эрхийг хангах тухайд
8. Мэдээллийн аюулгүй байдал-Нууц эх сурвалжийг хамгаалах тухайд

Мөн уг асуудалтай шууд бус холбогдох доорх судалгаануудыг Парламентын судалгааны хүрээлэнгээс хийсэн байна. Үүнд:

1. “Олон нийтэд төрийн бодлого шийдвэрийг хүргэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг оролцоо, гадаадын зарим орны туршлага, эрх зүйн зохицуулалт” СТ-16/206, Ө.Мөнхтунгалаг нар, Боть-23
2. “Парламентын хуралдааны үйл ажиллагааг телевиз, радиогоор нэвтрүүлдэг эсэх талаарх бусад орнуудын туршлага” СТ-16/211, А.Пагма нар, Боть-23
3. “Цахим болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдын нэр төрийг гутаах, гүтгэх, доромжлох, хуурамч мэдээлэл тараах үйлдэлд хүлээлгэх хариуцлага” СТ-17/201, Г.Алтан-Оч, И.Жаргалзаяабямба, Боть-24
4. “Парламентын нэгдсэн хуралдаан болон Байнгын хорооны хуралдааныг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулдаг эсэх талаарх судалгаа” СТ-17/410, Д.Жигваагүнсэл нар, Боть-25

¹ Д-р Ч.Базар “Мэдээллийн аюулгүй байдлын тухай зарим улс орны эрх зүйн зохицуулалт” СТ-11/213, УИХТГ-ын Судалгааны төв, Бодлогын судалгаа шинжилгээ Х боть, хуудас 73-91

Судалгааны оршил

Дэлхийн улс орнуудын мэдээлэл авах эрхийн тухай хууль нь хоорондоо төстэй байх нь түгээмэл байдаг талаар “Freedom of Information Around the World 2006” материалд тэмдэглэжээ. Энэ нь хуулиа батлан гаргаж буй орнууд хуультай орны туршлагыг загвар болгон ашиглаж байгаатай холбоотой юм. Тухайлбал, үүнд Америкийн хууль ихээхэн нөлөө үзүүлсэн байна. Түүнчлэн Канад, Австралийн холбооны болон муж улсын хуулийн загвар английн уламжлал бүхий орнуудад түгээмэл хэрэглэгдэж байна.

Дээрх материалд дурдсанаар дэлхийн улс орнуудын мэдээлэл авах эрхийн тухай хуульд дараах нийтлэг зохицуулалтын талаар тусгасан байна.

Мэдээлэл авах эрхийг хангах байгууллагууд /Types of bodies covered/

Мэдээлэл авах эрхийн тухай хууль нь голдуу төрийн хүнд суртал бүхий гүйцэтгэх болон захиргааны байгууллагууд болох үндэсний хэмжээний эрүүл мэнд, байгаль орчин, хууль сахиулах, цэргийн, харилцаа холбоо, тээврийн чиг үүргийн яам, агентлагууд, тэдгээрийн харьяа орон нутгийн байгууллагуудтай харилцах харилцааг зохицуулахад чиглэсэн байдаг. Цөөн тохиолдолд хууль тогтоох болон шүүх байгууллагатай харилцах харилцааг зохицуулж болно.

Хуульд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн болон бусад байгууллагыг тодорхой зааж өгөх нь чухал бөгөөд энэ нь хамгийн сайн туршлагад орно. Тухайлбал, Ирланд зэрэг зарим орон хуульдаа холбогдох байгууллагуудын нэрийг тодорхой (positive list of bodies) заасан байдаг. Ингэснээр хамааралтай болон хамааралгүй байгууллагуудыг ойлгоход илүү хялбар болох юм. Гэвч байгууллагыг үүсгэн байгуулах, нэр өөрчлөгдөх, бүтцийн өөрчлөлт хийгдэх болгонд парламентаар, эсхүл ямар нэг зохицуулалтаар уг жагсаалтыг шинэчлэн батлах шаардлага гарах бөгөөд үүнд ихээхэн цаг хугацаа зарцуулах болно. Түүнчлэн Засгийн газар шинэ байгууллагыг нэмэхээс татгалзах тохиолдолд асуудлыг илүү хүндрэлтэй болгоно. Тухайлбал, Ирландад цагдаагийн байгууллага хамааралгүй байна. Канадад хувьчлагдсан болон шинээр байгуулагдсан байгууллагын мэдээллийг авах нь ихээхэн маргаантай байдаг.

Зарим улс орнууд нууц мэдээлэл эзэмших тусгай байгууллагыг оруулдаггүй. Жишээлбэл, Их Британи, Энэтхэгт аюулгүй байдлын болон тагнуулын алба нь ордоггүй.

Энэ нь тухайн байгууллагын бүх үйл ажиллагааг хаалттай болгох ба ингэснээр авлигаас урьдчилан сэргийлэх, албан тушаалаа урвуулан ашиглах, тухайн байгууллагын мэдэлд буй байгаль орчинд учрах аюулын талаарх мэдээлэл зэрэг зайлшгүй хянах механизмыг байхгүй болгоно. Түүнчлэн бусад олон мэдээллийг хаалттай болгох юм.

Тиймээс үүнийг шийдэх сайн арга нь тухайн байгууллагыг хуулийн хүрээнд хамруулж нууцлах шаардлагатай мэдээллийн хувьд хамгаалах баталгаагаар хангах

² Freedom of Information Around the World 2006: A Global Survey of Access to Government Information Laws, David Banisar, page 20

https://www.researchgate.net/publication/228245794_Freedom_of_Information_Around_the_World_2006_A_Global_Survey_of_Access_to_Government_Information_Laws

³ МӨН ТЭНД

явдал юм.

Холбооны улсуудын хувьд холбооны хуулиас гадна муж улс бүр нь тус тусдаа хуультай байдаг. Эдгээр хуулиуд нь холбооны хуулиас өмнө батлагдсан байх бөгөөд дэвшилтэт заалтуудыг хожим холбооны хуульд тусгасан байна. Тухайлбал, Америкт бүх муж улс нь тус тусын нээлттэй засгийн газрын хуулийг баталсан бөгөөд тэдгээрийн зарим нь холбооны хууль батлагдахаас олон жилийн өмнө буюу 19-р зууны сүүл, 20-р зууны эхэн үед батлагджээ.

Ихэнх улс оронд хувийн хэвшлийн эзэмшиж буй мэдээллийн авах эрх нь хязгаарлагдмал байх бөгөөд зарим орны хуульд ийм мэдээллийг хэрхэн авч болох талаар зохицуулжээ. Тухайлбал, Өмнөд Африкийн Мэдээлэл авах эрхийг хангах тухай хууль нь хувь хүн болон төрийн байгууллагад шаардлагатай бол хувийн хэвшлийн мэдээллийг албадан авах болон бусад аргаар авч болох талаар зохицуулсан байна. Мөн зохицуулалтыг Антигуа болон Барбудагийн Мэдээлэл авах эрхийн тухай хуульд тусгажээ.

Авах боломжтой мэдээлэл /What is Accessible/4

Улс орнуудын мэдээлэл авах эрхийн тухай хуульд хувь хүн ямар мэдээллийг авах эрхтэй байх талаар янз бүрээр тодорхойлсон байдаг. Хуулиа эрт баталсан орнуудын хувьд бичлэг (records), албан ёсны бичиг баримт, файлд хандах эрх гэсэн бол хуулиа шинээр баталсан орнууд голдуу мэдээлэл авах эрх гэж тодорхойлсон байна. Практикт эдгээр тодорхойлолтын хувьд бараг ялгаа байхгүй.

Ихэнх орны хуульд хадгалсан арга хэрэгслээс үл хамааран бүх мэдээллийг авах эрхтэй байх талаар түгээмэл тодорхойлсон. Швед зэрэг зарим оронд боловсруулалтын шатанд буй бичиг баримтыг албан ёсны бичиг баримтад хамруулахгүй, мөн баримт бичгийн төслийг эцсийн шийдвэр гаргахад хэрэглэгддэггүй. Энэ нь мэдээллийн өргөн хүрээг хуулийн хамрах хүрээний гадуур үлдээх юм.

Энэтхэгийн Мэдээлэл авах эрхийн тухай хуулиар хувь хүн хоол хүнсийг амсаж үзэх, зам тавьж буй материалын дээжийг үзэх эрхийг олгосон байна.

Мэдээлэл авах эрх нь зөвхөн бичгэн мэдээлэлд хамааралтай байх талтай. Энэ нь шийдвэр гаргахад аман мэдээлэл (тухайлбал, хуралд хэлсэн үг) шаардлагатай тохиолдолд учир дутагдалтай байдаг. Үүнийг шийдэх сайн арга нь бүх төрлийн мэдээллийг авах боломжийг шаардах явдал юм. Тухайлбал, Дани Улсад шийдвэр гаргахад чухал шаардлагатай аман мэдээллийг хүлээн авсан байгууллага нь тэмдэглэх үүрэгтэй байна.

Мэдээлэл авах эрхийг эдлэх этгээд /Who can ask/5

Ихэнх улс орнууд хууль ёсны ашиг сонирхол, иргэний харьяалал, оршин суугаа газраас үл хамааран хүн бүрт мэдээлэл авах боломжийг олгоно. Финланд зэрэг зарим улсад хүсэлт гаргагчийг ялгаварлан гадуурхахгүй байхын тулд эзэн тодорхойгүй

4 Freedom of Information Around the World 2006: A Global Survey of Access to Government Information Laws, David Bainsar, page 22

https://www.researchgate.net/publication/228245794_Freedom_of_Information_Around_the_World_2006_A_Global_Survey_of_Access_to_Government_Information_Laws

5 МӨН ТЭНД

хүсэлт гаргахыг зөвшөөрдөг.

Хязгаарлагдмал мэдээллийг чөлөөлөх /Exemptions/6

Улс орнуудын мэдээлэл авах эрхийн тухай хуульд зарим мэдээллийг авах эрх хязгаарлагдмал байх нь нийтлэг байдаг. Үүнд үндэсний аюулгүй байдал, олон улсын харилцаа, хувийн нууц, худалдааны нууцлал, эрх зүйн албадлага болон нийгмийн хэв журам, нууцын мэдээлэл, дотоод хэлэлцүүлэг зэрэг орно. Ихэнх Парламентын засаглалтай улсуудад Засгийн газарт шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн бичиг баримтууд болон Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг тодорхой хугацаагаар авах эрхийг хязгаарладаг. Тухайлбал, Ирланд Улсад энэ нь арван жил байна. Харин Шинэ Зеландад Засгийн газрын баримт бичгийг хүсэлтийн дагуу цаг алдалгүй гаргаж өгдөг.

Ихэнх орны хуульд мэдээллийг, эсхүл түүний зарим хэсгийг нууцад оруулахын өмнө хор хохирлыг тогтоох талаар заасан. Хохирлын тест нь хамгаалагдах мэдээллийн төрлөөс хамааран өөр өөр байна. Хувийн нууц, дотоод шийдвэр, үндэсний аюулгүй байдлыг хамгийн өндөр түвшинд хамгаалах шаардлагатай байдаг.

Зарим орны хуульд "олон нийтийн ашиг сонирхлын тест" хэмээх ойлголтыг оруулсан байдаг. Энэ нь төрийн байгууллага болон хяналтын байгууллагад олон нийтэд ил болгох ашиг сонирхол болон мэдээлэл авах эрхийг хязгаарлах ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх үүрэг хүлээлгэнэ. Уг зохицуулалт нь мэдээллийг олон нийтэд ил болгох ашиг сонирхлын ач холбогдол нь ийнхүү ил болгосноор учируулах хор хохирлоос илүү тохиолдолд хор хохирол байгаа ч мэдээллийг олон нийтэд хүргэх боломжийг олгоно. Үүнийг ихэвчлэн зөрчил, авлига, түүнчлэн хувь хүн, хүрээлэн буй орчинд хор хөнөөл учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл түгээхэд ашигладаг. Зарим улсад үүнийг олон нийтэд чухал хамааралтай аливаа хэрэгцээний улмаас мэдээллийн хязгаарлалтыг чөлөөлөхөд хэрэглэнэ.

Ихэнх орны хуульд хохирлын түвшин нь буурсан тохиолдолд мэдээллийг ил болгох талаар зохицуулсан байна. Зарим орны хуульд тодорхой хугацааны хязгаарлалт тавьдаг. Тухайлбал, Мексикт Холбооны ил тод байдлын тухай хуульд энэ хугацааг арван хоёр жил байхаар заасан байна.

Хүлээлгэх хариуцлага /Sanctions/7

Бараг бүх улс орон мэдээлэл авах эрхийн тухай хуульдаа төрийн байгууллага, ажилтан хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар заасан байдаг.

Үүнд байгууллага эсхүл, ажилтан мэдээлэл өгөхөөс үндэслэлгүй татгалзах, баримт бичгийг өөрчлөх, устгах тохиолдлууд орно. Тухайн байгууллагад эсхүл, тухайн ажилтанд захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэж болно. Ихэнх орны хууль нь ноцтой зөрчилд торгууль ногдуулах түүнчлэн, шоронд хорих заалттай байдаг.

⁶ Freedom of Information Around the World 2006: A Global Survey of Access to Government Information Laws, David Banisar, page 22

https://www.researchgate.net/publication/228245794_Freedom_of_Information_Around_the_World_2006_A_Global_Survey_of_Access_to_Government_Information_Laws

⁷ Freedom of Information Around the World 2006: A Global Survey of Access to Government Information Laws, David Banisar, page 22-23

https://www.researchgate.net/publication/228245794_Freedom_of_Information_Around_the_World_2006_A_Global_Survey_of_Access_to_Government_Information_Laws

Тухайлбал, Польшийн Олон нийтийн мэдээллийг авах эрхийн тухай хуульд торгох, эрх чөлөөг нь хязгаарлах эсхүл, нэг жил хүртэл хугацаагаар хорих шийтгэл хүлээлгэхээр заасан.

Мэдээллийг цахимаар авах боломж /E-FOI/

Мэдээлэл авах эрхийг хангах бас нэг хэлбэр нь цахим системийг ашиглах явдал юм.

Ихэнх улс орнууд мэдээлэл авах эрхийн тухай хуулиар засгийн газрын байгууллагуудад цахим хуудсандаа тодорхой төрлийн мэдээллийг тогтмол гаргах үүргийг хүлээлгэсэн. Польшийн Олон нийтийн мэдээллийг авах эрхийн тухай хуулийн дагуу төрийн байгууллагууд өөрсдийн бодлого, хууль эрх зүйн зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, захиргааны акт болон шийдвэрийн агуулга, төрийн өмчийн талаарх нарийвчилсан мэдээллийг цахим хуудсаараа олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Эстоний Олон нийтийн мэдээллийн тухай хуулийн дагуу улсын болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, бусад олон нийтийн мэдээллийг эзэмшигчид цахим хуудас хөтлөх үүрэгтэй бөгөөд гэмт хэрэг, эдийн засгийн статистик зэрэг өргөн хүрээний мэдээллийн жагсаалтыг байрлуулах; байгууллагын статус болон бүтцийн нэгжийн талаар; ажилтны ажил үүргийн тодорхойлолт, тэдгээрийн хаяг, мэргэшил, цалингийн хэмжээ; эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл; төсөв, төсвийн төсөл; хүрээлэн буй орчны төлөв байдлын талаарх мэдээлэл; хуулийн төсөл, зохицуулалт, төлөвлөгөө зэрэг мэдээллийг цахим хуудсандаа байрлуулах үүрэгтэй. Мөн эдгээр мэдээллийг "хуучирсан, алдаатай, худал" биш гэдгийг баталгаажуулах шаардлагыг тавьдаг.

Европын холбооны зөвлөл нь мэдээлэл авах эрхийн талаарх журмын дагуу ихэнх баримт бичгээ цахим хэлбэрээр олгох боломжийг бүрдүүлсэн байна.

Ер нь хүсэлт гаргагч цахим шуудан эсхүл, цахим хуудсанд суурилсан маягтыг ашиглан мэдээлэл авах боломжтой. Тухайлбал, Турк Улсад гол яамдууд иргэдэд цахим сүлжээ ашиглан мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн бөгөөд хэрэглэгчийн онлайнаар гаргасан хүсэлтийг идэвхтэй дэмжиж ажилладаг.

Affirmative Publications* буюу *Proactive disclosure

Ихэнх улс орны хуульд засгийн газрын байгууллагуудад зарим төрлийн мэдээллээ тогтмол гаргах үүрэг хүлээлгэсэн нь нийтлэг зохицуулалтын нэг юм. Үүнд засгийн газрын бүтэц, үндсэн албан тушаалтнуудын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, хууль тогтоомжийн баримт бичиг, бодлого, төлөвлөгөө, маягт, шийдвэр зэрэг орно. Сүүлд хуулиа баталсан орнуудын хувьд зарим төрлийн хориглосон мэдээллийн жагсаалтыг гаргаж өгөх хандлагатай байна.

Мэдээллээр идэвхтэй хангах нь төрийн байгууллагуудад ч ашигтай бөгөөд зарим энгийн хүсэлтэд хариу өгөх ажлыг хөнгөвчлөх тул байгууллагын ачааллыг

⁸ Freedom of Information Around the World 2006: A Global Survey of Access to Government Information Laws, David Banisar, page 25

https://www.researchgate.net/publication/228245794_Freedom_of_Information_Around_the_World_2006_A_Global_Survey_of_Access_to_Government_Information_Laws

бууруулах юм. Тухайлбал, Европын холбооны зөвлөлийн 2003 оны жилийн тайланд хүмүүс шууд авах боломжтой баримт бичгийн тоо нэмэгдэхийн хэрээр хүсэлт гаргасан баримт бичгийн тоо буурсан талаар тэмдэглэжээ.

***Шүгэл үлээхүй /Whistleblowing/*¹⁰**

Зарим улс оронд мэдээлэл авах эрхийн тухай хуулиар шүгэл үлээгчийг хамгаалах асуудлыг зохицуулсан. Тухайлбал, Шведийн Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль нь төрийн албан хаагчид төрийн байгууллагын үйл ажиллагааг нэрээ нууцлан шүүмжлэх үндсэн эрхийг олгосон байна.

¹⁰ Freedom of Information Around the World 2006: A Global Survey of Access to Government Information Laws, David Banisar, page 25
https://www.researchgate.net/publication/228245794_Freedom_of_Information_Around_the_World_2006_A_Global_Survey_of_Access_to_Government_Information_Laws

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Энэхүү судалгаанд Казахстан, Эстони, Герман зэрэг улсуудын туршлагыг судлав. Судалгаанд захиалагчаас ирүүлсэн захиалгын дагуу эдгээр улсуудын ижил төрлийн хуулийг авч үзсэн бөгөөд тухайн хуулийн зохицуулах харилцаа, бүтэц, хамрах хүрээ, хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар судалсан болно.

Дээрх улсуудын туршлагыг тоймлон авч үзвэл:

Хуулийн зохицуулах харилцаа.

Судалгаанд хамрагдсан улсууд нь хуулийн зохицуулах харилцааг доорх байдлаар тодорхойлсон байна.

Германы Мэдээллийн эрх чөлөөний хуулиар иргэн хүнд Холбооны Улсын яам, төрийн байгууллага болон Холбооны Улс (ХУ)-ын бусад байгууллагуудын албан ёсны мэдээлэлд хандах эрх олгож, мэдээлэл авах харилцааг зохицуулдаг.

Казахстаны Мэдээлэл авах эрхийн тухай хууль нь хүн бүр хуулиар хориглоогүй аливаа хэлбэрээр мэдээллийг чөлөөтэй авах, түгээх зэрэг Үндсэн хуулиар олгосон эрхээ хэрэгжүүлэхэд холбогдох харилцааг зохицуулна.

Эстоний Олон нийтийн мэдээллийн тухай хуулийн (*Public Information Act*) зорилго нь олон нийт, хүн бүр ардчилсан нийгмийн засаглал болон нээлттэй нийгмийн зарчимд суурилсан олон нийтэд нээлттэй мэдээллийг ашиглах, нээлттэй байх боломжийг хангах, түүнчлэн, мэдээллээр хангах үүргийн хэрэгжилтийг хянах боломж бүрдүүлэхэд оршино.

Хамрах хүрээ

Герман. Мэдээллийн эрх чөлөө нь зөвхөн эцэслэн батлагдсан бичиг баримтад хамаатай. Хувийн болон байгууллагын мэдээлэлд хамааралгүй бөгөөд зөвхөн хүсэлт гаргагчийн мэдээллийн ашиг сонирхол нь тухайн хүний хамгаалах ашиг сонирхлоос хэтийдсэн, эсхүл хувь хүн өөрөө зөвшөөрсөн бол хувийн мэдээлэлд хандах эрх олгоно. Гэхдээ хувийн хэрэг болон хувийн хэргийн систем доторх агуулгад хандаж мэдээлэл авах эрхгүй байна. (*Мэдээллийн эрх чөлөө нь Үндсэн хуульд тусгасан “үгээ хэлэх эрх чөлөөтэй” холбоогүй бөгөөд “мэдээлэлд хандах”, “ил тод байдал”, “акттай танилцах” зэрэг утгаар хэрэглэгдэнэ.*)

Казахстан. Тус хууль нь нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллийг авахтай холбогдох харилцааг зохицуулна. Бусад хууль тогтоомжоор зохицуулсан өргөдөл гаргах, хүсэлт хянан үзэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх журам зэрэгт хамааралгүй байна.

Эстони. Уг хууль нь мэдээллийг авах, дахин хэрэглэх нөхцөл, журам, арга; мэдээлэл өгөхөөс татгалзах; зарим хязгаарлагдмал мэдээллийг авах журам; мэдээллийн санг бүрдүүлэх, удирдан зохион байгуулах, хянах; мэдээллийн хүртээмж, түүнд төрөөс тавих хяналт зэрэг асуудлыг хамаарна. Нууцын зэрэглэлтэй мэдээлэл, гадаадын мэдээлэл, бусад хуулиар зохицуулагдсан зарим архивын мэдээ баримт болон олон улсын гэрээ, эсхүл тусгай хуульд зохицуулсан мэдээлэлд хамааралгүй болно.

Хариуцлага

Герман Улс нь Мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд мэдээллийн аюулгүй байдлын талаарх гол зохицуулалтаа тусгасан бөгөөд хариуцлагын талаар Эрүүгийн хуульд зохицуулжээ.

Казахстан Улсын хувьд мэдээлэл авах эрхийг хууль бусаар зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар Захиргааны зөрчлийн тухай хуульд тусгасан бөгөөд мөнгөн торгууль хүлээлгэхээр заасан байна.

Эстони Улс нь Олон нийтийн мэдээллийн тухай хуулиараа (*Public Information Act*) хариуцлагын асуудлыг зохицуулсан бөгөөд мөнгөн торгууль хүлээлгэхээр тусгасан. Түүнчлэн хууль зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хууль болон Жижиг гэмт хэргийг хянан шийдвэрлэх хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТУУД

1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Зохицуулах харилцаа. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар иргэн хүнд Холбооны Улсын яам, төрийн байгууллага болон Холбооны Улс (ХУ)-ын бусад байгууллагуудын албан ёсны мэдээлэлд хандах эрх олгож, мэдээлэл авахыг нь зохицуулдаг. Ингэхдээ эрх зүй, эдийн засаг, аж ахуй, эсхүл өөр ямар ч байдалтай бай ашиг сонирхлоо илэрхийлэх, нотлох албагүй.

Захиргааны процессын тухай хуульд зааснаар ХУ-ын яам, төрийн байгууллага нь хувийн хэвшлийн хуулийн этгээд буюу бие хүнд үйлчлэх үүргийн дагуу хүссэн мэдээллийг нь хувийн хэвшлийн этгээдэд гаргаж өгснөөр мэдээлэл өгөх үүргээ хэрэгжүүлж, хандах эрхийг хангадаг.

“Мэдээллийн эрх чөлөө” гэдэг ойлголт нь өргөн хүрээтэй, олон салаа утгатай учир буруу ойлгогдох эрсдэлтэй аж. Мэдээллийн эрх чөлөө нь Үндсэн хуульд тусгагдсан “Үгээ хэлэх эрх чөлөө”-тэй огт холбоогүй юм. Тиймээс “Мэдээлэлд хандах”, “Ил тод байдал” (Хамбург муж улс), эсхүл “Акттай танилцах” (Бранденбург муж улс) хэмээх ойлголтууд илүү оновчтой ажээ.

Мэдээллийг цаашид хэрхэн ашиглах асуудлыг энэ хуулиар бус харин Мэдээллийг цаашид ашиглах тухай хуулиар зохицуулж байна.

Хамрах хүрээ. Холбооны Улсын Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль¹¹ 2006 оны 1-р сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхлэхээс өмнө Холбооны Улсын хэмжээнд иргэн нь төрийн байгууллагын акттай танилцах эрхгүй байсан. Энэ хооронд ХБНГУ-ын 13 муж улс өөрийн эрх мэдлийн хүрээнд тусдаа Муж Улсын мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг баталж, мөрдүүлээд байна.

Бавари, Нидерзаксен болон Заксен гэсэн гурван муж улсууд ийм тусгайлсан хуульгүй аж.

Харин Хамбург, Бремен, Райнланд-Пфалц муж улсад мэдээлэл авах хүсэлт гаргахаас гадна мэдээлэлжүүлэх үүрэг бүхий байгууллагууд мэдээллийг идэвхтэй хэвлэн нийтлэж байхаар зохицуулсан Ил тод байдлын тухай хуультай ажээ.

Уг хуульд мэдээлэлд хандах эрхийг хязгаарлагдмал хангах, эсхүл бүр мөсөн гаргаж өгөхгүй байх олон хориглох заалтууд тусгагдсан байна.

Мэдээллийн эрх чөлөө нь зөвхөн эцэслэн батлагдсан бичиг баримтад хамаатай бөгөөд төлөвлөлтийн шатанд яваад хандах эрхийг олгохгүй.

Мэдээллийн эрх чөлөөнд цаашлаад хувийн болон байгууллагын мэдээлэл багтахгүй. Хүсэлт гаргагчийн мэдээллийн ашиг сонирхол нь тухайн хүний хамгаалах ашиг сонирхлоос хэтийдсэн, эсхүл хувь хүн өөрөө зөвшөөрсөн бол хувийн мэдээлэлд хандах эрх олгоно. Гэхдээ хувийн хэрэг болон хувийн хэргийн систем доторх агуулгад хандаж мэдээлэл авах эрхгүй. Нэр болон ажилтны албан байгууллагын хаягийн тухай

¹¹ Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль (*герман*)-Informationsfreiheitsgesetz
<https://de.wikipedia.org/wiki/Informationsfreiheitsgesetz>

мэдээлэлд хандах эрхийг үндсэндээ хангана. Энэ нь мэргэжлийн шинжээчийн мэдээлэлд мөн хамаарна.

Холбооны Улсын Мэдээний болон Үндсэн хуулийг хамгаалах албанд салбарын түвшинд хорио тогтоосон аж. Эдгээр нь Холбооны Улсын сангийн яам лугаа мэдээлэл өгөх үүрэг багатай ч 2013 онд ХУ-ын нэгдсэн төсвийн журамд оруулсан өөрчлөлтөөр тухайн салбарыг уг хуулийн хамрагдах хүрээнээс гаргажээ.

Бундестаг нь Германы Бундестагийн Судалгааны албаны боловсруулсан ажлуудыг нийтлэхийг олон жил цааргалсны эцэст 2015 онд ХУ-ын Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гарч, 2016 оны 2-р сарын 18-ны өдрөөс хойш захиалгын дагуу боловсруулсан бүх мэргэжлийн шинжээчийн дүгнэлтийг Бундестагийн веб хуудаст нийтэлдэг болсон байна.

Хуулийн бүтэц. Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль (“Холбооны Улсын Мэдээлэл хандалтын зохицуулалтын тухай хууль”)¹² нь доорх зүйл заалтаас бүрдэнэ. Үүнд:

1. Ерөнхий зүйл
2. Нэр томьёо, ойлголтын тодорхойлолт
3. Нийтийн тусгай зүйлийг хамгаалах
4. Төрийн байгууллагын шийдвэр гаргах процессыг хамгаалах
5. Хувь хүнтэй холбоотой өгөгдлийг хамгаалах
6. Оюуны өмч болон байгууллага, аж ахуйн нэгжийн нууцыг хамгаалах
7. Хүсэлт гаргах ба процесс
8. Гуравдагч этгээдийн оролцооны процесс
9. Хүсэлтийг татгалзах; Шүүх
10. Хураамж, төлбөр
11. Хэвлэн нийтлэх үүрэг
12. Мэдээллийн эрх чөлөөний Холбооны Улсын Төлөөлөгч
13. (Гарчиггүй)
14. Тайлан, үнэлгээ
15. Хүчин төгөлдөр болох

Процесс. Төрийн байгууллага нь ерөнхийдөө зөвхөн хүсэлтийг үндэслэн мэдээллээр хангах боломж олгоно. Ингэхдээ “даруйхан” мэдээлэл өгөх, акттай танилцах боломж олгох, эсхүл “бусад байдлаар”, жишээлбэл, ярианы бичлэг сонсгох буюу мэдээллийн санд хайлт хийлгүүлнэ. Хүсэлт нь хэвшмэл загваргүй бичгээр үйлдсэн байх, эсхүл амаар буюу телефон утсаар байж болно. Төрийн байгууллага нь 500 евро хүртэлх хэмжээний төлбөр, хураамж авч болно. Хүсэлтийг гүйцэтгэхэд Захиргааны хэргийн процессын тухай хуульд заасан журмыг мөрдөнө. Хүсэлтийг татгалзах нь захиргааны акт бөгөөд шүүхэд давж заалдах боломжтой.

Байгууллагын нууц үгүй болсноор, гуравдагч этгээдэд мэдээлэл өгөхийг нийтлэг байдлаар хориглох боломжгүй болдог. Иймд төрийн байгууллагууд тохиолдол бүр дээр гуравдагч этгээдийн хамгаалах үнэ цэн, дээд түвшний ашиг сонирхол зэргийг сайтар нягталж шалгасны эцэст мэдээлэл гаргаж өгөх хэрэгтэй болж байна.

¹² Холбооны Улсын Мэдээлэл хандалтын зохицуулалтын тухай хууль (Мэдээллийн эрх чөлөөний хууль)- Gesetz zur Regelung des Zugangs zu Informationen des Bundes <https://www.gesetze-im-internet.de/ifg/>

Хүлээлгэх хариуцлага. ХБНГУ-д Мэдээллийн эрх чөлөөний хуулиар мэдээллийн аюулгүй байдлын гол зохицуулалтаа хийгээд “хариуцлага”-ын талаар Эрүүгийн хуульдаа тусгасан нь дэвшилттэй буюу мэдээлэл аль болох нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэхэд илүү дөхөмтэй болсныг судлаачид тэмдэглэдэг.¹³

2. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС

Тус улсад мэдээлэл авах эрхийн талаарх асуудлыг Мэдээлэл авах эрхийн тухай хуулиар (*О доступе к информации*) зохицуулдаг.

Зохицуулах харилцаа. Энэ хууль нь хүн бүр хуулиар хориглоогүй аливаа хэлбэрээр мэдээллийг чөлөөтэй авах, түгээх зэрэг Үндсэн хуулиар олгосон эрхээ хэрэгжүүлэхэд холбогдох харилцааг зохицуулна¹⁴.

Хуулийн бүтэц. Мэдээлэл авах эрхийн тухай хууль (*О доступе к информации*) нь 21 зүйлтэй байна. Үүнд:

- 1 дүгээр зүйл. Үндсэн ойлголт
- 2 дугаар зүйл. Мэдээлэл авах талаарх Казахстан улсын хууль тогтоомжууд
- 3 дугаар зүйл. Хуулийн хамрах хүрээ
- 4 дүгээр зүйл. Мэдээлэл авах эрхийг хангах үндсэн зарчим
- 5 дугаар зүйл. Мэдээлэл авах эрхийг хязгаарлах
- 6 дугаар зүйл. Авах эрхийг хязгаарлаагүй мэдээлэл
- 7 дугаар зүйл. Мэдээлэл ашиглагчийн эрх, үүрэг
- 8 дугаар зүйл. Мэдээлэл эзэмшигч
- 9 дүгээр зүйл. Мэдээлэл эзэмшигчийн эрх, үүрэг
- 10 дугаар зүйл. Мэдээлэл авах эрхийг хангах арга замууд
- 11 дүгээр зүйл. Хүсэлтийн дагуу мэдээлэл өгөх
- 12 дугаар зүйл. Мэдээлэл эзэмшигч нь байрлаж буй байрандаа мэдээллийг хэрхэн байршуулах тухай
- 13 дугаар зүйл. Төрийн байгууллага болон тэдгээрийн харьяа байгууллагуудын хуралдааны талаарх мэдээллийг авах эрхээр хангах
- 14 дүгээр зүйл. Төв гүйцэтгэх байгууллагын удирдлага, Засаг дарга, үндэсний дээд боловсролын байгууллагын дарга нарын тайлан
- 15 дугаар зүйл. Мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх
- 16 дугаар зүйл. Интернетийн орчинд мэдээлэл байршуулах
- 17 дугаар зүйл. Мэдээллийг "Цахим засгийн газар" цахим хуудсанд байршуулах
- 18 дугаар зүйл. Мэдээлэл авах эрхийг хууль бусаар хязгаарласан талаар гомдол гаргах
- 19 дүгээр зүйл. Мэдээлэл авах асуудлыг хариуцах комиссын тухай
- 20 дугаар зүйл. Мэдээлэл авах тухай хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага
- 21 дүгээр зүйл. Хуулийг хэрэгжүүлэх журам зэрэг болно.

¹³ Ч.Базар 2011

¹⁴ Мэдээлэл авах эрхийн тухай хууль (*О доступе к информации*), <http://adilet.zan.kz/rus/docs/Z1500000401>

Хамрах хүрээ¹⁵. Энэ хууль Казахстан Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллийг авахтай холбогдох харилцааг зохицуулна. Захиргааны хэргийн тухай, Эрүүгийн байцаан шийтгэх тухай, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад заасан хувь хүн болон хуулийн этгээдийн гаргасан өргөдөлд хамааралгүй. Мөн Үндэсний архивын сан болон архивын тухай хуульд заасан хүсэлт хянан үзэх талаарх журамд хамааралгүй болно. Түүнчлэн, Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуульд тусгасан хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл өгөх журамд хамааралгүй байна.

Хүлээлгэх хариуцлага¹⁶. Мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийг зөрчвөл Казахстан улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Мэдээлэл авах эрхийг хууль бусаар хязгаарлах тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар Захиргааны зөрчлийн тухай хуульд (*Об административных правонарушениях*) зохицуулсан байна¹⁷. Үүнд:

1. Мэдээлэл өгөхөөс үндэслэлгүй татгалзах, санаатай буруу мэдээлэл өгөх тохиолдолд албан тушаалтан, жижиг үйлдвэрлэл эрхлэгч, ашгийн бус байгууллагад 30, дунд үйлдвэрлэл эрхлэгчид 50, томоохон үйлдвэрлэл эрхлэгчид 100 торгуулийн нэгжтэй тэнцэх мөнгөн торгууль ногдуулна.
2. Интернетийн орчин, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр худал, буруу мэдээлэл түгээх тохиолдолд албан тушаалтан, жижиг үйлдвэрлэл эрхлэгч, ашгийн бус байгууллагад 30, дунд үйлдвэрлэл эрхлэгчид 50, томоохон үйлдвэрлэл эрхлэгчид 100 торгуулийн нэгжтэй тэнцэх мөнгөн торгууль ногдуулна.
3. Авах эрхийг хязгаарлаагүй мэдээллийг хязгаарласан мэдээллийн ангилалд оруулах тохиолдолд албан тушаалтанд 20 торгуулийн нэгжтэй тэнцэх мөнгөн торгууль ногдуулна.
4. 1 болон 3-т заасан тохиолдлыг захиргааны хариуцлага хүлээлгэснээс хойш 1 жилийн дотор давтан үйлдвэл албан тушаалтан, жижиг үйлдвэрлэл эрхлэгч, ашгийн бус байгууллагад 50, дунд үйлдвэрлэл эрхлэгчид 100, томоохон үйлдвэрлэл эрхлэгчид 300 торгуулийн нэгжтэй тэнцэх мөнгөн торгууль ногдуулна.

*Жич: торгуулийн нэгж (месячный расчетный показатель) нь 2020 оны байдлаар 2525-2651 тенгетэй тэнцүү байна*¹⁸. Тенге нь Казахстан улсын мөнгөн тэмдэгт болно.

¹⁵ Мэдээлэл авах эрхийн тухай хууль (*О доступе к информации*), 3 дугаар зүйл, <http://adilet.zan.kz/rus/docs/Z1500000401>

¹⁶ Мэдээлэл авах эрхийн тухай хууль (*О доступе к информации*), 20 дугаар зүйл <http://adilet.zan.kz/rus/docs/Z1500000401>

¹⁷ Захиргааны зөрчлийн тухай хууль (*Об административных правонарушениях*), 456-1 дүгээр зүйл <http://adilet.zan.kz/kaz/docs/K1400000235>

¹⁸ https://finance.kz/articles/2020_zhyl_aylyq_eseptik_korsetkish_aek_pen_en_tomengi_zhalaqy_molsheri_etzh-1402

3. БҮГД НАЙРАМДАХ ЭСТОНИ УЛС

Эстони улсад уг асуудлыг Олон нийтийн мэдээллийн тухай хуулиар (*Public Information Act*) зохицуулж байна.

Зохицуулах харилцаа¹⁹. Энэхүү хуулийн зорилго нь олон нийт, хүн бүр ардчилсан нийгмийн засаглал болон нээлттэй нийгмийн зарчимд суурилсан олон нийтэд нээлттэй мэдээллийг ашиглах, нээлттэй байх боломжийг хангах, түүнчлэн, мэдээллээр хангах үүргийн хэрэгжилтийг хянах боломж бүрдүүлэхэд оршино.

Хуулийн бүтэц. Олон нийтийн мэдээллийн тухай хууль (*Public Information Act*) нь дараах бүлгүүдтэй байна. Үүнд:

- 1 дүгээр бүлэг. Ерөнхий зүйл
- 2 дугаар бүлэг. Мэдээлэл авах эрх бүхий байгууллагууд
- 3 дугаар бүлэг. Хүсэлтийн дагуу мэдээлэл авах зөвшөөрөл олгох
- 4 дүгээр бүлэг. Мэдээллийг тодруулах
- 5 дугаар бүлэг. Хязгаарлагдмал мэдээлэл
- 5¹ дугаар бүлэг. Мэдээллийн сан
- 6 дугаар бүлэг. Хяналт
- 6¹ дугаар бүлэг. Хүлээх хариуцлага
- 7 дугаар бүлэг. Хэрэгжүүлэх нөхцөл зэрэг болно.

Хамрах хүрээ²⁰. Энэ хууль нь дараах асуудлыг хамаарна. Үүнд:

- мэдээлэл авах болон мэдээллийг дахин хэрэглэх нөхцөл, журам, арга, түүнчлэн, мэдээлэл өгөхөөс татгалзах үндэслэл;
- ашиглах эрх нь бусад хууль тогтоомжид зохицуулагдаагүй хязгаарлагдмал мэдээллийг авах эрх олгох журам;
- мэдээллийн сан бүрдүүлэх, удирдах үндэслэл, мэдээллийн сангийн удирдлагын хяналт;
- мэдээллийн хүртээмжийг зохион байгуулахад төрийн хяналт тавих журам зэрэг болно.

Хуульд дараах асуудлууд хамааралгүй байна. Үүнд:

- нууцад хамаарах хугацаа дуусаагүй төрийн нууцын зэрэглэлтэй эсхүл, гадаадын мэдээлэл;
- Архивын тухай хуульд заасан журмын дагуу хэрэглэгдэх Үндэсний болон орон нутгийн засаг захиргааны архивын мэдээ, баримтууд (авах эрхийг хязгаарласнаас бусад);
- Санамж бичгийн хариу болон тайбар хүсэх тухай хуульд (*Response to Memoranda and Requests for Explanations Act*) заасан журмын дагуу хариу

¹⁹ Олон нийтийн мэдээллийн тухай хууль (*Public Information Act*), 1 дүгээр бүлэг, 1 дүгээр зүйл <https://www.riigiteataja.ee/en/eli/514112013001/consolide>

²⁰ Олон нийтийн мэдээллийн тухай хууль (*Public Information Act*), 1 дүгээр бүлэг, 2 дугаар зүйл, <https://www.riigiteataja.ee/en/eli/514112013001/consolide>

өгөхдөө бүртгэгдсэн мэдээллийг судалж дүн шинжилгээ хийх, нэмэлт мэдээлэл цуглуулах, баримтжуулах шаардлагатай тохиолдол;

- мэдээлэл авах журам, арга хэлбэр нь олон улсын гэрээ, эсхүл тусгай хуульд өөрөөр зохицуулагдсан хязгаарлагдмал мэдээлэл болон тусгай нөхцөл бүхий мэдээлэл зэрэг орно.

Түүнчлэн энэ хуультай холбоотой захиргааны хэрэгт холбогдох асуудлыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулна.

*Хүлээлгэх хариуцлага*²¹. Хуульд зааснаар олон нийтэд буруу мэдээлэл түгээх, дотоод хэрэгцээнд зориулагдсан мэдээллийг задруулах эсхүл, Мэдээлэл хамгаалах газрын (*Data Protection Inspectorate*) дүрэм, зааврыг дагаж мөрдөөгүй бол 300 хүртлэх нэгжтэй тэнцэх мөнгөн торгуулиар торгох шийтгэл хүлээлгэнэ.

Мөн хууль зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хуулийн (*Penal Code*) Ерөнхий хэсэг болон Жижиг гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн (*Code of Misdemeanour Procedure*) дагуу хариуцлага хүлээлгэнэ.

²¹ Олон нийтийн мэдээллийн тухай хууль (*Public Information Act*), 6¹ дугаар бүлэг, 54¹ дүгээр зүйл, <https://www.riigiteataja.ee/en/eli/514112013001/consolide>

Ашигласан материал

- Олон нийтийн мэдээллийн тухай хууль (*Public Information Act*)
<https://www.riigiteataja.ee/en/eli/514112013001/consolide>
- Мэдээлэл авах эрхийн тухай хууль (*О доступе к информации*)
<http://adilet.zan.kz/rus/docs/Z1500000401>
- Захиргааны зөрчлийн тухай хууль (*Об административных правонарушениях*),
<http://adilet.zan.kz/kaz/docs/K1400000235>
- Төрийн өмчийн тухай хууль (*О государственном имуществе*), 1 дүгээр зүйл
<http://adilet.zan.kz/rus/docs/Z110000041>
- Холбооны Улсын Мэдээлэл хандалтын зохицуулалтын тухай хууль
(Мэдээллийн эрх чөлөөний хууль) - Gesetz zur Regelung des Zugangs zu
Informationen des Bundes
<https://www.gesetze-im-internet.de/ifg/>
- Freedom of Information Around the World 2006: A Global Survey of Access to
Government Information Laws, David Banisar
https://www.researchgate.net/publication/228245794_Freedom_of_Information_Around_the_World_2006_A_Global_Survey_of_Access_to_Government_Information_Laws